



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/100/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
(Дорноговь аймаг, Сайншанд хот)  
2018 он

Тэргүүлэх аудитор: ..... Ч.Ариунаа  
Утас: 7052-2734      Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn  
Аудитын менежер: .....  
Утас: 7052-3020      Цахим хаяг: .....Ц.Лүндэгмаа  
Аудитор: ..... Л.Баасандорж  
Утас: 9905-5703      Цахим хаяг: baskal88@yahoo.com

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.10	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.11	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	12
2.12	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3	Менежментийн захидал .....	13
	<b>3.2 БАТЛАГДСАН ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ .....</b>	<b>15</b>
	<b>3.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....</b>	<b>16</b>
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	17
	<b>4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>17</b>
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21

## 1 Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ХӨВСГӨЛ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
З.МӨНГӨНБАГАНА**

2019-02-20 № 1-6/13  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЕБС-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



**Аудитын гол асуудал:**

- 2018 онд дотуур байранд амьдарч буй сурагчдын хоол, хүнсний материалд 28.9 сая төгрөгийн дотуур байрны хүүхдийн хоол, 133 сая төгрөгийн сурагчдын үдийн цай, 13,550.9 мян.төгрөгийг нүүрсний худалдан авалт, нийт 55.4 сая төгрөгийн худалдан авалтанд ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1.1 болон 33 дугаар зүйл, заалтуудтай нийцэхгүй байна.
- 2018 оны төсвийн хэмнэлтээр 2019 оны зардлыг санхүүжүүлэхээр авлага үүсгэж, НДХ, Татварын хэлтэст нийт 348.2 мян.төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 45, 46 дугаар зүйл, заалтууд болон Сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан "Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-тай үл нийцэж байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал З.Мөнгөнбаганад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.12.17-наас 2019.02.13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газраас хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Суралцагч нэг бүрийн сурлагын чанарыг ахиулж, өөртөө итгэлтэй иргэн болгон төлөвшүүлнэ.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмээр Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Үгүй

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт хөрөнгө*-ын 1 хувиар сонгов.

*Нийт хөрөнгө*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудиторын гүйцэтгэж буй сорил нь хөрөнгийн эрсдэлтэй холбоотой тул нийт хөрөнгийг суурь болгон сонгосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны *Нийт хөрөнгө* 1,754,859.27 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 17,548.59 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь хөрөнгийн дүнд суурилсан эрсдэл үүсгэх ажил гүйлгээнүүд нь уг дүнгээс доош тохиолдолд аливаа шийдвэр гаргалтад үр нөлөөгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	348.16	
3	Албан шаардлага өгсөн	1	55,429.89	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	55,778.05	

**2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

2018 оны төсвийн хэмнэлтээр 2019 оны зардлыг санхүүжүүлэхээр авлага үүсгэж, НДХ, Татварын хэлтэст 348.2 мян.төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь үнэн зөв байх, оршин байх, бодитой байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 45 дугаар зүйл “Төсвийн хэмнэлт”, 46 дугаар зүйл “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах журам” зэрэг заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тавих, актын төлбөрийг хүү торгуулийн орлогын дансанд 2019 онд батлагдсан төсвөөс төлж барагдуулах, авлага бүхий байгууллагатай холбогдох тооцоог дуусгах, хэрэгжилтийг 2019 оны 3 дугаар сарын 25-нд багтаан гүйцэтгэх

**Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

Дотуур байрны хүүхдийн хоол, сурагчдын үдийн цай, нүүрсний худалдан авалт зэрэг нийт 55.4 сая төгрөгийн 3 төрлийн худалдан авалтад ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1.1 “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33 дугаар зүйл “Харьцуулалтын арга” зэрэг заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгч, биелэлтийг 2019 оны 12-р сарын 25-ний дотор Дорноговь аймгийн Төрийн аудитын байгууллагад ирүүлэх, дараа жилийн аудитаар үргэлжлүүлэн авч үзэх асуудалд тодорхойлов.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

ТБОНӨХБАҮХАТХ-ийн хэрэгжилт  
НББ-ийн бодлогын баримт бичгийн мөрдөлт ба хэрэгжүүлэлт

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, 36 арга хэмжээнд зориулан 2018 онд 436,917.80 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 431,796.78 мянган төгрөг буюу 98.83 хувьтай байгаа нь цалингийн зардал 4,816.3 мян.төгрөгөөр, НДШ-ийн зардал 113.86 мян.төгрөгөөр, тогтмол зардал 7.55 мян.төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 255.92 мян.төгрөгөөр, нормативт зардал 106.17 мян.төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 106.11 мян.төгрөгөөр, томилолт зочны зардал 3.0 мян.төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 32.8 мян.төгрөгөөр, үдийн цай 116.6 мян.төгрөгөөр хэмнэгдэж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 351.49 мян.төгрөгөөр хэтэрснээс шалтгаалжээ. Үүнд дотор цалингийн зардлын хэмнэлт их байгаа нь жилийн эцэст унаа хоолны хөнгөлөлт, ур чадварын нэмэгдэл олгохоор тооцсон боловч ИТХ-аар батлуулж амжаагүйтэй холбоотой байна.

Тус байгууллага нь 2018 онд спорт залны төлбөртэй үйлчилгээ, түрээсийн төлбөрөөс 2,113.0 мянган төгрөг төвлөрүүлж зарцуулсан.

### **2.10 Шилэн дансны мэдээлэл**

Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100% хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 ХУДАЛДАН АВАЛТ БОЛОН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ, ХЭРЭГЖИЛТ

#### Илрүүлэлт

28.9 сая төгрөгийн дотуур байрны хүүхдийн хоол, 13.3 сая төгрөгийн сурагчдын үдийн цай, 13.5 сая төгрөгийг нүүрсний худалдан авалт, нийт 55.4 сая төгрөгийн худалдан авалтад ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1.1 болон 33 дугаар зүйл, заалтуудтай нийцэхгүй байна.

#### Эрсдэл

Холбогдох хуулийг хэрэгжүүлээгүйгээс хуулийн хариуцлага хүлээх, ашиг сонирхлын зөрчил үүсэх

#### Зөвлөмж

Тайлант оны худалдан авалтыг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлж ажиллах

#### Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Мөнгөнбагана

#### Төсвийн захирагчийн хариу

Хуулийн зарим заалтыг хэрэгжүүлж иргэд байгууллагад санал хүргүүлж ажилласан. Орон нутагт хуулийг мөрдөж ажиллахад бэрхшээл тулгардаг. Худалдаа эрхэлдэг ААН, иргэд цөөн, санал ирүүлэхээс татгалздаг, хуулийн талаар мэдлэг муу учраас хамгийн хямд үнийг сонгож шууд гэрээ байгуулсан. Зарим бүрдүүлэх бичиг баримт дутуу бүрдүүлсэн зэрэг асуудлаас болсон.

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.13-нд бичгээр ирүүлсэн болно.

### 3.2 БАТЛАГДСАН ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

#### Илрүүлэлт

2018 оны төсвийн хэмнэлтээр 2019 оны зардлыг санхүүжүүлэхээр авлага үүсгэж, НДХ, Татварын хэлтэст нийт 348.2 мян.төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 45, 46 дугаар зүйл, заалтууд болон Сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-тай үл нийцэж байна.

#### Эрсдэл

Төсөвт байгууллагын хөрөнгө, нэмэлт орлогыг дутуу бүртгэх

#### Зөвлөмж

Тухайн төсвийн жилд үүссэн хэмнэлтээс авлага үүсгэхгүй ажиллах, Төсвийн тухай хуулийн 6.4.8 дугаарт заасанчлан “төсвийг үр ашигтай удирдаж, өглөг авлагагүй ажиллах”, мөн тухайн жилийн батлагдсан төсвөөс хэмнэгдсэн хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлж байх. Төсвийн тухай хуулийн 45 болон 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ийг дагаж мөрдөж ажиллах

#### Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Мөнгөнбагана

#### Төсвийн захирагчийн хариу

2018 оны жилийн эцсийн гүйлгээтэй холбоотой 12 дугаар сарын 24-ний өдөр төсөв зоогдож, 25, 26-ны өдрүүдэд гүйлгээ хийгдэж хаасан тул ачаалал үүсч өглөг, авлага үүсгэхэд хүргэсэн.

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.13-нд бичгээр ирүүлсэн болно.

### 3.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

#### Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоходоо холбогдох салбарынхаа НБББББ-ийг дагаж мөрдөхгүй, хүчингүй болсон Сангийн сайдын 233 тоот тушаалыг зарим эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлаж байна. Хүчин төгөлдөр бус аргачлал ашиглан үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тогтоосноос үүдэн үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг буюу дансны үнэ, нийт хөрөнгө болон эх үүсвэр, тайлант үеийн үр дүн буруу тодорхойлогдох эрсдэл үүсч байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтад нийцэхгүй байна.

#### Эрсдэл

Хөрөнгийн бодит үнэ цэнэ буруу тооцоологдож санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

#### Зөвлөмж

БСШУСЯ-аас салбарын түвшинд дагаж мөрдөхөөр боловсруулан баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа жишиг бодлогын баримт бичгийг ашиглах, эсвэл өөрийн байгууллагын онцлогт тохируулан нэмж сайжруулан, засварлаж хэрэглэх

#### Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Мөнгөнбагана

#### Төсвийн захирагчийн хариу

Байгууллага боловсруулж баталсан НБББББ-т заасан хувь хэмжээг мөрдөж ажиллах байгаа

*Жич: Үйлчлүүлэгч дээрх хариуг ирүүлж байгаа боловч аудитын явцад бидэнд байгууллага НБББББ-ийг ирүүлж танилцуулаагүй болно.*

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.13-нд бичгээр ирүүлсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6-р сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ч.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ц.ЛҮНДЭГМАА

БЭЛТГЭСЭН: АУДИТОР:

Л.БААСАНДОРЖ

#### 4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>49,464,649.60</b>	<b>56,009,318.62</b>
33	<b>АВЛАГА</b>	333,600.00	414,461.00
335	<b>Бусад авлага</b>	333,600.00	414,461.00
3351	Байгууллагаас авах авлага	333,600.00	414,461.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	49,131,049.60	55,594,857.62
351	<b>Түүхий эд материал</b>	9,778,750.00	13,164,550.00
35110	Тусгай зориулалттай материал	9,665,350.00	12,974,350.00
35130	Эм боох материал	113,400.00	190,200.00
354	<b>Хангамжийн материал</b>	38,112,299.60	41,190,307.62
35410	Бичиг хэргийн материал	2,172,632.20	2,615,360.20
35420	Аж ахуйн материал	29,248,872.40	34,233,248.40
35440	Түлш, шатах тослох материал	3,923,100.00	2,946,179.02
35450	Барилгын засварын материал	196,350.00	766,350.00
35460	Хүнсний материал	2,571,345.00	629,170.00
35600	Мал амьтад	1,240,000.00	1,240,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,818,464,223.74</b>	<b>1,698,916,260.48</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,818,464,223.74	1,698,916,260.48
392	<b>Биет хөрөнгө</b>	1,818,447,817.74	1,672,078,260.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,772,843,361.00	1,518,773,540.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,113,679,293.92	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	164,631,993.51	143,677,947.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,531,272.54	-74,160,639.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,451,196.61	79,155,564.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,083,019.85	-37,639,785.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,611,120.00	35,003,110.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,180,141.73	-4,697,000.62
39217	Ном	11,383,874.66	11,965,524.66
393	<b>Биет бус хөрөнгө</b>	16,406.00	26,838,000.00
39301	Програм хангамж	375,000.00	705,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-358,594.00	-375,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	26,508,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,867,928,873.34</b>	<b>1,754,925,579.10</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,909,100.00</b>	<b>191,083.92</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,909,100.00	191,083.92
413	<b>Өглөг</b>	3,909,100.00	191,083.92
4131	<b>Ажилчидтай холбогдсон өглөг</b>	2,511,704.00	0.00
4132	<b>Бараа үйлчилгээний зардлын өглөг</b>	1,252,970.00	163,883.92
4136	<b>Бусад өглөг</b>	144,426.00	27,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	99,000.00	27,200.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	45,426.00	00.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,864,019,773.34</b>	<b>1,754,734,495.18</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,864,019,773.34	1,754,734,495.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	321,619,099.90	321,619,099.90
51101	Өмч: - төрийн	321,619,099.90	321,619,099.90
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	696,220,224.51	364,690,537.04
51210	Өмнөх үеийн үр дүн	696,220,224.51	771,441,716.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-406,751,179.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	846,180,448.93	1,068,424,858.24
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,867,928,873.34</b>	<b>1,754,925,579.10</b>

##### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>362,028,534.00</b>	<b>475,362,756.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,437,650.00</b>	<b>33,551,356.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,437,650.00	33,551,356.00

Хөвсгөл сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,437,650.00	32,677,356.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	91,800.00	1,239,050.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,345,850.00	31,438,306.00
120009	Бусад орлого	00.00	874,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>348,999,584.00</b>	<b>441,811,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>341,893,500.00</b>	<b>438,395,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	341,893,500.00	436,917,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	1,477,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	5,591,300.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,106,084.00</b>	<b>3,416,400.00</b>
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	7,106,084.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,416,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>325,979,584.38</b>	<b>501,385,653.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>325,979,584.38</b>	<b>501,385,653.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>291,203,984.38</b>	<b>461,744,329.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>190,891,443.00</b>	<b>290,102,621.00</b>
210101	Үндсэн цалин	176,600,410.00	231,022,776.00
210102	Нэмэгдэл	5,427,894.00	27,380,360.00
210104	Урамшуулал	8,863,139.00	26,326,668.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	5,372,817.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,474,198.51</b>	<b>35,559,045.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,656,834.51	31,514,484.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,952,197.00	994,689.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,570,322.00	821,322.00
210204	Ажилгүйдлийн даатгал	390,438.00	201,512.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,904,407.00	2,027,038.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,787,516.00</b>	<b>24,291,766.90</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,814,516.00	6,687,145.00
210302	Түлш, халаалт	7,592,400.00	15,630,221.90
210303	Цэвэр, бохир ус	1,380,600.00	1,974,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,685,127.30</b>	<b>5,409,539.00</b>
210401	Бичиг хэрэг	1,670,176.00	1,184,150.00
210402	Тээвэр, шатахуун	1,452,010.00	1,871,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,040.00	00.00
210404	Ном, хэвлэл	00.00	76,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000.00	596,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,511,901.30	1,681,469.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,785,270.00</b>	<b>30,763,390.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,000.00	105,000.00
210502	Хоол, хүнс	20,710,270.00	30,658,390.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>1,544,400.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	1,544,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>210,000.00</b>	<b>618,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	210,000.00	618,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>670,200.00</b>	<b>1,033,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	406,400.00	953,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	263,800.00	80,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,200,229.57</b>	<b>72,421,767.54</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,000.00	241,891.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,718,660.00	1,369,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,361,569.57	70,810,076.54
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>00.00</b>	<b>5,121,024.00</b>

Хөвсгөл сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2121	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	00.00	5,121,024.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	5,121,024.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	34,775,600.00	34,520,300.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,775,600.00	34,520,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,017,400.00	13,501,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,758,200.00	20,818,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	200,000.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>36,048,949.62</b>	<b>-26,022,897.44</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	380,728,281.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	4,032,208.80
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	107,800.13
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	376,588,273.02
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-380,728,281.95
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>36,048,949.62</b>	<b>-406,751,179.39</b>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>354,682,684.00</b>	<b>443,924,450.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>91,800.00</b>	<b>2,113,050.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	91,800.00	2,113,050.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	91,800.00	1,239,050.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	91,800.00	1,239,050.00
120009	Бусад орлого	00.00	874,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>354,590,884.00</b>	<b>441,811,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	341,893,500.00	438,395,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	341,893,500.00	436,917,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	1,477,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	5,591,300.00	00.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,106,084.00	3,416,400.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	7,106,084.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,416,400.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>288,037,933.00</b>	<b>443,783,800.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>288,037,933.00</b>	<b>443,783,800.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>253,262,333.00</b>	<b>404,280,171.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	185,022,132.00	290,710,689.00
210101	Үндсэн цалин	122,708,346.00	178,147,641.00
210102	Нэмэгдэл	41,594,726.00	63,222,898.00
210104	Урамшуулал	8,653,163.00	28,275,679.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,065,897.00	21,064,471.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,461,496.00	38,771,437.00
210201	Тэтгэврийн даатгал	14,647,680.00	37,639,187.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,453,452.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,162,761.00	287,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	290,689.00	40,250.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,906,914.00	805,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,593,116.00	22,190,845.00
210301	Гэрэл, цахилгаан	5,924,516.00	6,687,145.00
210302	Түлш, халаалт	6,288,000.00	13,550,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,380,600.00	1,952,800.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,193,405.00	7,514,373.00
210401	Бичиг хэрэг	249,985.00	871,578.00
210402	Тээвэр, шатахуун	1,321,610.00	2,056,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,040.00	00.00
210404	Ном, хэвлэл	00.00	84,000.00

Хөвсгөл сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	232,820.00	586,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,367,950.00	3,916,115.00
2105	<b>Нормативт зардал</b>	18,909,860.00	29,212,511.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,000.00	181,800.00
210502	Хоол, хүнс	18,799,860.00	28,581,491.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,000.00	449,220.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	750,000.00	4,553,825.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,500,000.00
210602	Тавилга	00.00	556,000.00
210604	Урсгал засвар	750,000.00	2,497,825.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	177,000.00	457,800.00
210702	Дотоод албан томилолт	177,000.00	457,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	406,400.00	1,171,491.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	406,400.00	1,171,491.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,748,924.00	9,697,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,000.00	495,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,628,924.00	9,202,200.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,775,600.00</b>	<b>39,503,629.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,775,600.00	34,316,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,017,400.00	13,297,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,758,200.00	20,818,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	200,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	5,187,329.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,187,329.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>66,644,751.00</b>	<b>140,650.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>32,920,300.00</b>	<b>140,650.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>32,920,300.00</b>	<b>140,650.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	32,920,300.00	140,650.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,920,300.00	140,650.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-32,920,300.00</b>	<b>-140,650.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	33,724,451.00	00.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	33,514,056.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	33,514,056.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	321,619,099.90	846,180,448.93	645,980,995.08	1,813,780,543.91
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>321,619,099.90</b>	<b>846,180,448.93</b>	<b>645,980,995.08</b>	1,813,780,543.91
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-31,817,949.91	-31,817,949.91
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>321,619,099.90</b>	<b>846,180,448.93</b>	<b>696,220,224.51</b>	1,864,019,773.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	75,221,491.92	75,221,491.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>321,619,099.90</b>	<b>846,180,448.93</b>	<b>771,441,716.43</b>	1,939,241,265.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	222,244,409.31	00.00	222,244,409.31
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-406,751,179.39	-406,751,179.39
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>321,619,099.90</b>	<b>1,068,424,858.24</b>	<b>364,690,537.04</b>	1,754,734,495.18

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	436,917,800.00	431,796,776.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	436,917,800.00	431,796,776.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	402,484,900.00	397,480,476.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	292,110,600.00	287,294,289.00
210101	Үндсэн цалин	179,950,600.00	174,731,241.00
210102	Нэмэгдэл	62,944,000.00	63,222,898.00
210104	Урамшуулал	28,150,100.00	28,275,679.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,065,900.00	21,064,471.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,885,300.00	38,771,437.00
210201	Тэтгэврийн даатгал	27,910,700.00	37,639,187.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,743,600.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,194,900.00	287,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	548,800.00	40,250.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,487,300.00	805,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,198,400.00	22,190,845.00
210301	Гэрэл, цахилгаан	5,810,000.00	6,687,145.00
210302	Түлш, халаалт	15,358,400.00	13,550,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,030,000.00	1,952,800.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,314,200.00	7,058,278.00
210401	Бичиг хэрэг	781,500.00	871,578.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,056,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	406,000.00	224,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	482,000.00	586,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,110,700.00	3,319,370.00
2105	<b>Нормативт зардал</b>	29,232,800.00	29,212,511.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	181,800.00
210502	Хоол, хүнс	28,652,800.00	28,581,491.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	380,000.00	449,220.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,210,000.00	3,103,825.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,710,000.00	1,603,825.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	460,800.00	457,800.00
210702	Дотоод албан томилолт	460,800.00	457,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	820,000.00	1,171,491.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	820,000.00	1,171,491.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8252800.00	8220000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	527,800.00	495,000.00
201902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,725,000.00	7,725,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	34432900.00	34316300.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,432,900.00	34,316,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,414,100.00	13,297,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,818,800.00	20,818,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	200,000.00	200,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	436,917,800.00	436,295,519.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	436,917,800.00	436,295,519.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	436,917,800.00	436,295,519.00